

**НИЙСЛЭЛИЙН ХҮҮХДИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ЭРҮҮЛ ҮРС ТӨВИЙН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2026 оны 06 сарын 08

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Монгол улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ-ийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Зорилт 1. Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин бууруулах зорилтын хүрээнд, сэргээн засах төвөөр хэвтэн эмчлүүлж буй хүүхдүүдийн цар хүрээг нэмэгдүүлэн, хоол тэжээлийн дуталтай хүүхдүүдийг эмчлэн, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, хоол тэжээлийн дутлыг тогтвортой бууруулна.

1.1.Сэргээн засах төвийн бүтэц, орон тоо

Сэргээн засах төвийн бүтэц, үйл ажиллагаа” MNS 6801-2019 стандарт, “Бүтэц, дүрэм, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” НЭМГ-ын даргын 2024 оны А/36 тоот тушаалыг тус тус үндэслэн “Сэргээн засах төвийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд баримтлах журам”-ыг төвийн даргын 2024 оны А/11 тоот тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

1. Сэргээн засах төвийн бүтэц

- Амбулатори, хүүхэд хүлээн авах яаралтай тусламжийн хэсэг
- Сэргээн засах өдрийн эмчилгээний тасаг
- Сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тасаг
- Сувилахуйн баг
- ЭМ-н даатгал, статистик мэдээлэл

2. Захиргаа, санхүүгийн алба

- Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
- Хүний нөөцийн менежер
- Санхүү хөрөнгө оруулалт
- Архив, бичиг хэрэг
- Хамтын ажиллагаа, сургалтын хэсэг
- Аж ахуйн хэсэг оруулалт бүхий нийт орон тооны дээд хязгаар нь 49 бүхий үйл ажиллагаа явуулж байна.

Эмчилгээний хэсэг, нэгжийн урсгал зөв, эрүүл ахуйн шаардлага хангасан. Тус тушаалд эмчилгээний хэсгийн бүтэц зохион байгуулалтыг тусгасан ба эмчилгээний

хэсгүүд өглөө 08.20 цагаас орой 17.20 цаг хүртэл, бусад хугацаанд жижүүр эмч, сувилагч, асрагчтай 18 хүүхэд хүлээн авах хүчин чадал бүхий хэвтэн эмчлүүлэх ортой, 49 ажилтан батлагдсан орон тоотой одоогоор 36 ажилтантай ажиллаж байна.

Сэргээн засах төвийн оношилгоо эмчилгээнд мөрдөгдөх стандарт удирдамжийн жагсаалтыг гарган төвийн даргын тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Төвийн даргын даргын 2024 оны А/25 тоот “Жагсаалт батлах тухай” тушаалын нэгдүгээр, хоёрдугаар хавсралтаар батлагдсан 42 төрлийн стандарт удирдамж, эрх зүйн баримт бичиг мөрдөж байна.

Үүнд:

- стандарт
- 13 удирдамж 29 – н дагуу тусламж үйлчилгээг үзүүлдэг.

Уламжлалт эмчилгээний төрөл:

- Бариа эмчилгээ
- Төөнө эмчилгээ
- Засал эмчилгээ
- Зүү эмчилгээ

Сэргээн засах эмчилгээ:

- Физик эмчилгээ
- Хөдөлгөөн засал эмчилгээ зэрэг багтаж байна.

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв нь MNS 6801:2019 стандартын дагуу эмч эмнэлэгийн мэргэжилтэний хувийг тогтмол нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

1.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж

🇮🇪 2026 оны хагас жилийн байдлаар нийт 2010 хүүхэд сэргээн засах төвөөр үйлчлүүлсэн байна. Үүнээс:

- Амбулаторийн тусламж үйлчилгээ 502 хүүхэд
- Урьдчилан сэргийлэх үзлэг 1508 хүүхэд
- Хэвтэн эмчлүүлэх тасагт /станционар/ 204 хүүхэд
- Өдрийн сэргээн засах эмчилгээнд нийт 57 хүүхэд
- Сэргээн засах төвөөс зөвлөгөө аван буцсан 250 хүүхэд байна.

№	Үзүүлэлт	2025 он	2026 он
1	Урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо	791	1508
2	Амбулаторийн тоо	469	502
3	Өдрийн эмчилгээ	44	57
	Буцсан	162	250
	Идэвхитэй хяналт	1	
	Хэвтэн эмчлүүлсэн	263	204
Нийт		1260	2010

Хүснэгт 1. Статистик харьцуулсан үзүүлэлт

Сэргээн засах төвийн орны фонд ашиглалт:

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн статистик тоон мэдээллийг сар тутамд тайлагнан ажиллаж байна.

Хүүхдийн сэргээн засах төвийн хэмжээнд:

№	Үзүүлэлт	2025	2026
1.	Хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн тоо	263	204
2.	Ор хоног	1789	1428
3.	Орны фонд ашиглалт		35.7%
4.	Орны фонд ашиглалтын хувь		115.2%
5.	Дундаж ор хоног	6.0	7.0
6.	Орны эргэлт		5.1

Хүснэгт 2. Статистик харьцуулсан үзүүлэлт




График 1. Төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн насны ангилал

🏠 2026 оны эхний хагас жилийн байдлаар зорилтот бүлгийн 0-5 хүртэлх насны хүүхдүүдийг өдрийн эмчилгээнд хуваарийн дагуу бүрэн хамруулж, тэдний сэргээн засах эмчилгээ болон асаргаа сувилгааны нэн шаардлагатай хэрэгцээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулан ажиллалаа. 0-5 хүртэлх насны нийт 24 хүүхдийг сэргээн засах өдрийн эмчилгээнд төлөвлөгөөний дагуу амжилттай хамруулан ажиллалаа.

Өдрийн эмчилгээний хөтөлбөрийн хүрээнд хүүхэд бүрийн онцлог, хэрэгцээнд тохируулан дараах сэргээн засах тусламж, үйлчилгээг цогцоор нь үзүүллээ. Үүнд:

- **Уламжлалт болон бариа засал:** Зөөлөн засал болон ширүүн засал эмчилгээ
- **Сэргээн засах хөдөлгөөн засал:** Хөдөлгөөн засал эмчилгээ
- **Физик эмчилгээ:** Физик эмчилгээ болон бумба эмчилгээ

Төлөвлөгөөт өдрийн эмчилгээг тогтмолжуулснаар хүүхдүүдийн асаргаа сувилгааны чанар сайжирч, сэргээн засах эмчилгээний үр дүн болон хүүхдүүдийн бие махбодын өсөлт, хөгжилд эерэг ахиц дэвшил гарлаа.




График 2. Өдрийн эмчилгээний үр дүн



Зураг 1. Өдрийн эмчилгээний явц

✚ Эрүүл үрс хүүхдийн сэргээн засах төв нь 2026 оны хагас жилийн байдлаар нийт

2010 хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээг 204 хүүхдэд, өдрийн эмчилгээг 57 хүүхдэд, урьдчилан сэргийлэх үзлэгийг 1508 хүүхдэд үзүүлсэн байна.

Сэргээн засах төвөөр хөгжлийн бэрхшээлтэй 96 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн ба нийт хэвтэн эмчлүүлсэн 204 хүүхдүүдийн 47%-ийг эзэлж байна.




График 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эзлэх хувь

Сэргээн засах төвөөр хөгжлийн бэрхшээлтэй 47 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн ба нийт хэвтэн эмчлүүлсэн 204 хүүхдүүдийн 14%-ийг эзэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг авч үзвэл:



График 4. Төвөөр үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хувиар илэрхийлсэн байдал.

Хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн шалгуур-GMFM88 үнэлгээг өөрийн байгууллагат нэвтрүүлэн 2026 оны хагас жилд сэргээн засах төвөөр хэвтэн эмчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй 115 хүүхдүүдийг хэвтэх үед болон эмчилгээний дараа GMFM-88 үнэлгээнд хамруулснаас тулгуур эрхтний бэрхшээлтэй 59 хүүхдэд хөдөлгөөн засал болон уламжлалт сэргээн засахын эмчилгээ хавсран хийгдсэн байна. Хүүхдийн хөдөлгөөний хөгжлийн шалгуур-GMFM88 үнэлгээний 5 үзүүлэлтийн үр дүнд:

№	Үзүүлэлт	Анх ирэх үед	Давтан үзлэг үед сайжирсан
1.	Хэвтэх хөрвөх чадваргүй	21	14
2.	Суух чадваргүй	18	9
3.	Мөлхөх ба өвдөглөх чадваргүй	13	5
4.	Зогсох чадваргүй	5	2
5.	Явах чадваргүй	2	1
6.	Нийт хүүхдийн тоо	59	31

Хүснэгт 3. Үнэлгээний явцын байдал



Зураг 2. Хөдөлгөөн засал эмчилгээний явцаас



Зураг 3. GMFM88 үнэлгээний хуудас

🚦 Сэргээн засах төвийн хүрээнд 2026 оны хагас жилийн байдлаар эмчилгээ, оношилгооны нийт 45 стандарт, удирдамжийг мөрдөн ажиллаж байна.

Сэргээн засах төвд:

1. Бүтэн биеийн зөөлөн бариа 238 хүүхдэд 1070
2. Рашаан дэвтээлэг эмчилгээ 1152 хүүхдэд 1275
3. Цахилгаан төөнө эмчилгээ 35 хүүхдэд 210
4. Бумба эмчилгээ 238 хүүхдэд 1022
5. Тенс эмчилгээ 20 хүүхдэд 110
6. Ультразвук эмчилгээ 8 хүүхдэд 40
7. Лазер эмчилгээ 11хүүхдэд 45 удаа гэх мэт 33 нэр төрлийн уламжлалт заслын болон сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлснээр 92.5% нь сайжирсан үр дүнтэй байна.

Сэргээн засах төвөөр хэвтэн эмчлүүлсэн нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 27.8%-д нь сэргээн засах эмчилгээ, 22.6%-д нь уламжлалт эмчилгээ хийгдсэн ба 49.6%-д нь сэргээн засах болон уламжлалт эмчилгээ хавсран хийгдсэн байна.

Сэргээн засах төвд мөрдөгдөж буй MNS 4621:2008 түгээмэл үйлдлийн стандартын дагуу дараах уламжлалт эмчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Эмчилгээний нэр		Хүүхдийн тоо/ Давтамжийн тоо
Зөөлөн засал эмчилгээ	Бүтэн биеийн зөөлөн бариа	238 хүүхдэд
		1070 удаа
	Арвайтай бариа	199 хүүхдэд
		199 удаа
	4 толион бариа	238 хүүхдэд
		897удаа
	Толгойн бариа	32хүүхдэд
		160удаа
	Арвайтай жин	123 хүүхдэд
		612 удаа
	Хөлийн массажны аппарат-	160 хүүхдэд
		714 удаа
	Чихний лаа	133 хүүхдэд
		549 удаа
	Ганга цацлага	56хүүхдэд
		56 удаа
	Рашаан эмчилгээ	1152 хүүхдэд
		1275 удаа
Ширүүн засал эмчилгээ	Усан эмчилгээний ванн	53 хүүхдэд
		98 удаа
Соруул засал эмчилгээ	Хөлийн дүрлэг	41 хүүхдэд
		84 удаа
	Цахилгаан төөнүүр	35 хүүхдэд
		210 удаа
Соруул засал эмчилгээ	Галтай бумба	190 хүүхдэд
		828 удаа
	Галгүй бумба	48 хүүхдэд
		194 удаа

Хүснэгт 4. Эмчилгээний явц

ЭМС-ын 2022 оны 07-р сарын 04-ны өдрийн А/352 тоот тушаалын хавсралт, Нийслэлийн хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төвийн даргын 2024 оны А/20 тоот Үйлчлүүлэгчийг зөв таних тушаалын шинэчлэн батлан тус тушаалын дагуу дараах үйл ажиллагааг хийн ажиллалаа.

Төвөөр үйлчлүүлсэн хүүхдүүдийн дунд эрсдэлийн үнэлгээ хийж, үйлчлүүлэгчийг зөв танин тодруулан онцгой анхаарал шаардлагатай дараах бүлгүүдийг тодорхойлон, хяналтад авч ажиллаж байна.

- Эм, тариа харшилтай — **20 хүүхэд**
- Унах, бэртэх өндөр эрсдэлтэй — **69 хүүхэд**
- Тулгуур эрхтний бэрхшээлтэй — **27 хүүхэд**

Эмчилгээ сувилгааны ажилбар, үйлдэл хийх бүрд үйлчлүүлэгчийг зөв таньж тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор 4 өнгийн бугуйвчийг ашиглаж байна. Үүнд:

- Харшилтай - **улаан** өнгийн бугуйвч
- Унах эрсдэлтэй- **шар** өнгийн бугуйвч
- Танин мэдэхүйн алдагдалтай үйлчлүүлэгч
- Эмчилгээний хоол шаардлагатай үйлчлүүлэгч

Ижил нэртэй үйлчлүүлэгч зэргийг бугуйвчаар болон цахим өвчний түүхэнд тэмдэглэн ажиллаж байна.

Сэргээн засах төв нь тусламж үйлчилгээг чанар хүртээмжтэй хүргэхийн тулд хэвтэн эмчлүүлэгч бүрд өнгийн бугуйвчийг зүүж, өвчний түүхэнд тухайн хүүхдийг тэмдэглэснээр эмчлэг эмч төдийгүй, эмч сувилагч нар тухайн хүүхдийн онцлог байдлыг мэдэх боломжтой болсон байна.



Зураг 4. Цахим программыг ашиглаж буй төлөв

2026 оны эхний хагас жилийн хугацаанд хоол үйлдвэрлэлийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны 12 сарын 12-ны өдрийн 440 тоот тушаал, “Хүүхдийн зонхилон тохиолдох эмгэгийн үеийн эмчилгээний хоол” MNS 6325:2012, Хоол

үйлдвэрлэл үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал MNS CAC RCP 39:2011, Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн даргын 2024оны 03сарын 12 өдрийн А/08 дугаар тушаалыг тус тус үндэслэн эмчилгээний хоолны чанар, стандартыг олон улсын түвшинд хүргэх зорилгоор дараах ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

- **Нотолгоонд суурилсан судалгаа:** "UpToDate" олон улсын цахим платфрмоос сэргээн засах эмчилгээ болон эмнэлгийн хоол судлалын (диетологи) чиглэлээрх хамгийн сүүлийн үеийн удирдамж, судалгааны материалуудыг түүвэрлэн судалж, харьцуулалт хийв.
- **Удирдамж, заавар боловсруулалт:** Судалгааны үр дүнд тулгуурлан, өөрийн төвийн үйлчлүүлэгчдийн (ялангуяа хүүхэд, зорилтот бүлгийн) өвчний онцлог, асаргаа сувилгааны хэрэгцээнд нийцсэн **"Эмчилгээний хоолны шинэчилсэн удирдамж, заавар"**-ыг боловсруулан Стандарт хэмжилзүйн газрын Нийслэлийн лабораторид хоолны илчлэг /ккал/ тодорхойлох шинжилгээг өгөв. Шинжилгээний дүнд байгууллагын технологи картын илчлэг /ккал/-тай таарч байна.

Олон улсын эмнэлзүйн нотолгоонд суурилсан удирдамжийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр эмчилгээний хоолны чанар сайжирч, сэргээн засах төвөөр үйлчлүүлж буй хүүхдүүдийн биеийн жингийн дутал болон хоол тэжээлийн дутлыг эмчлэхэд чухал үр нөлөөтэй байна.



Зураг 5. Up to date платформыг ашиглаж кредит цуглуулсан байдал



Зураг 6. Эмчилгээний хоолны зураг

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв нь 2026 оны байдлаар Хоол хүнсний аюулгүй байдлыг хангах, хянах зорилгоор хүнсний бүтээгдэхүүнийг “Хүнс хангамж ХХК”-тай гэрээ хийн, гэрээний дагуу гарал үүслийн гэрчилгээ болон лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авч үйлчлүүлэгчдийн хоолыг хийн ажиллаж байна. Мөн хүнсний бүтээгдэхүүнийг олон сараар хадгалалгүй, амархан муудах хүнсийг 7 хоног болгон шинээр захиалан авч хүнсэндээ хэрэглэж байна.



Зураг 7. Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичиг

1.3. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг:

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 06 сарын 17-ны А/379 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд цэцэрлэгийн насны хүүхдүүдийн хоол тэжээлийн цочмог дутагдал /ХТЦД/ болон хавтгай тавхай эрт илрүүлэх үзлэг, үнэлгээг зохион байгууллаа.

Тус эрт илрүүлгийн үйл ажиллагаа нь 2026 оны 03 сарын 23-26-ны хооронд болон 05 сарын 04-аас 05 сарын 05-ны өдрүүдэд явагдсан бөгөөд Эрүүл үрс төвийн эмч, сувилагч, туслах сувилагч нар ажилласан.

Үйл ажиллагааг байгууллагын нөөц боломжид тулгуурлан зохион байгуулж нийт 18 цэцэрлэгийн 53 бүлгийн 1508 хүүхдийг үзлэгт хамруулан, ХТЦД болон хавтгай тавхайн эрт илрүүлгийн ажлыг зохион байгуулсан байна. Эрт илрүүлгийн үзлэгийг дараах цэцэрлэгүүдэд зохион байгуулж ажиллаа.

Үүнд:

- ✓ Сонгинохайрхан дүүргийн Нийслэлийн 294, 195, 244, 215, 260, 263, 214, 252, 261, 264, орбит шинэ хотхон цэцэрлэгүүд
- ✓ Чингэлтэй дүүргийн Нийслэлийн 102, 222, 246, 43 цэцэрлэгүүд, мөн 24 цагийн үйл ажиллагаа явуулдаг 83-р цэцэрлэгүүдэд үзлэг илрүүлэг зөвлөгөө, хяналтад хамруулах ажлыг зохион байгуулсан.



Зураг 8. Эрт илрүүлэгийн явцаас

Хоол тэжээлийн цочмог дутлын илрүүлэгт хамрагдсан нийт 1508 хүүхдүүдийн

- ✓ эрэгтэй-762
- ✓ эмэгтэй- 746 хүүхэд байсан ба хүйсийн байдлаар харахад хамрагдалт жигд байна.




График 5. Хүйсийн байдлаар харахад

Насны ангиллаар нь авч үзэхэд:

- ✓ 2 настай 38 хүүхэд / 2,5% /
- ✓ 3 нас 132 хүүхэд / 8,7% /
- ✓ 4 нас 500 хүүхэд / 33,7% /
- ✓ 5 нас 838 хүүхэд /55,5% /




График 6. Насны ангиллаар харахад

ХТЦД-ын илрүүлэгт хамрагдсан нийт 1508 хүүхдүүдээс хоол тэжээлийн дутал илэрсэн болон жингийн илүүдэлтэй хүүхдүүдийн тоог авч үзвэл:

Илрүүлэг нийт хамрагдсан хүүхдийн тоо-1508		
Z оноо	Нийт илэрсэн хүүхдийн тоо	Эзлэх хувь
-3	7	0,5%
-2	40	2,7%
-1	240	15,9%
Хэвийн	1086	72%
+1	96	6,3%
+2	35	2,3%
+3	4	0,3%

Хүснэгт 5. Илрүүлэгт хамрагдсан нийт хүүхдийн тоо




График 8. Z оноогоор авч үзвэл

Тус үзүүлэлтээс харахад хүнд тураалтай болон таргалалт бүхий хүүхдийн тоо буурсан хэдий ч тураал, туранхай онош тавигдахгүй ч жингийн дутагдалтай хүүхдүүд тодорхой хэмжээгээр илэрч байгаа нь цаашид энэ үзүүлэлтийг бууруулахгүйн тулд хоол тэжээлийн дутлаас сэргийлэх боломжтой харагдаж байна.

Тус хүүхдүүдэд цэцэрлэг болон эцэг эхтэй хамтран дараах арга хэмжээг авч ажилласан байна.

№	Үзүүлэлт ангилал	-1,-2,-3 хүүхдийн тоо	Авсан арга хэмжээ	Үр дүн
1	(-1) буюу Хөнгөн зэргийн ХТЦД	240	Хоол зүйч болон цэцэрлэгийн багш нартай хамтран эцэг эхчүүдэд хооллолтын зөвлөгөө өгсөн.	Хооллолтын дадал сайжирсан.
2	(-2) буюу туранхай ХТЦД	40	Эдгээр хүүхдүүдийн 31 хүүхэд нь амбулаториор ирж эмчилгээний бэлэн хоолны сорилыг даван өөрийн биеийн жинд тохирох хэмжээгээр эмчилгээний бэлэн хоолыг 7 хоногийн хугацаанд идэхээр авч яваад дахин 7 хоногийн дараа ирж биеийн жингээ үзүүлэн хянагдаж, 11 хүүхэд нь хөнгөн хэлбэрт шилжсэн. Үлдсэн хүүхдүүд нь эмчилгээний дундаас эмчилгээг орхисон. Эцэг эхэд хооллолт, асаргааны зөвлөгөө өгсөн.	11 хүүхэд жин нэмэгдэж сайжирсан үзүүлэлттэй байна.
3	(-3) буюу тураалтай ХТЦД	7	-3 бүхий тураалтай 7 хүүхдийн 2 хүүхэд нь ЭБХ идэж /-2/ болж жингийн хүнд хэлбэрийн тураалаас гарсан байна.	Хяналтад хамрагдсан 3 хүүхдийн 2 нь жин нэмэгдэж /-2/ шилжсэн байна.

Хүснэгт 6. Авсан арга хэмжээний талаарх

0-5 хүртэлх насны СХД болон ЧД-т байрлаж буй 18 цэцэрлэгийн хүүхдүүдэд өндөр жингийн үзүүлэлтээс хүйсийн байдлыг хоол тэжээлийн дуталтай харьцуулан харахад эмэгтэй хүүхдүүд өртөх магадлал өндөр харагдаж байна.




График 9. Хүйсээр харуулбал

0-5 хүртэлх насны СХД болон ЧД-т байрлаж буй 18 цэцэрлэгийн хүүхдүүдийн хүйсийн харьцааг харахад 53,4% эмэгтэй, 46,8% эрэгтэй хүүхдүүд эзэлж байна. Үүнээс харахад эмэгтэй хүүхдүүд хоол тэжээлийн дуталд өртөх магадлал өндөр харагдаж байна.

Туранхай, өсөлтийн хоцрогдолтой хүүхдүүдэд манай сэргээн засах төв нь эцэг эхийн хамт ирж үзүүлэн хооллолтын зөвлөгөө авахыг цэцэрлэгийн багш нарт зөвлөгөө өгч ажилласан.



Зураг 8. Багшид зөвлөгөө өгч буй явцаас

ХТЦД-тай хүүхдээс 11 хүүхэд ирж эмчилгээний бэлэн хоолны /печень/ сорил тавьж, сорилыг амжилттай даван, гэрээр эмчилгээний бэлэн хоолыг үргэлжлүүлэн идүүлэхээр авч явсан. Үүнээс 5 хүүхэд 7 хоногийн дараа давтан үзлэгтээ ирэн дараагийн ЭБХ идэж байна. Дээрх хүүхдүүдийн биеийн жин, өндөр, бугалганы тойргыг хэмжин нэмэгдэл, эмчилгээний үр дүнг тооцон, эмчилгээг үргэлжлүүлэн ажиллаж байна.

14 хоногийн жингийн нэмэгдэл (үр дүн):

- **Дөлгөөн-Аялгуу:** +900 гр
- **Хангал:** +800 гр
- **Анар:** +800 гр
- **Эрдэм:** +700 гр
- **Үжингоо:** +300 гр нэмсэн үр дүн гарсан байна.



Зураг 9. Эмчилгээний бэлэн хоол идэж буй явцаас



Зураг 10. Эмчилгээний бэлэн хоол идэж буй явцаас

🌈 2026 оны эхний хагас жилийн байдлаар хэвтэн эмчлүүлсэн болон өдрийн эмчилгээнд хамрагдсан нийт 251 хүүхдийн 110 буюу 43.8%-г 0-5 насны хүүхэд эзэлж байна. Тус хүүхдүүдийг ХӨЦМ-ийн стандартын дагуу үнэлэн, сэргээн засах эмчилгээтэй хослуулснаар хүүхдүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ илүү үр

дүнтэй цогц эмчилгээ болсон бөгөөд эмчилгээний явцад суурь өвчин хүндрэх, гэнэтийн эрсдэл үүсэх тохиолдлыг бууруулж, эмчилгээний чанарын үзүүлэлтийг ахиулж ажиллаж байна.

Сэргээн засах төвөөр хэвтэн эмчлүүлсэн нийт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн 27.8%-д нь сэргээн засах эмчилгээ, 22.6%-д нь уламжлалт эмчилгээ хийгдсэн ба 49.6%-д нь сэргээн засах болон уламжлалт эмчилгээ хавсран хийгдсэн байна. Мөн төв нь хөгжлийн бэрхшээлтэйгээс гадна:

Эрүүл үрс төвөөр хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн оношын байдлаар




График 9. Хэвтэн эмчлүүлэгчийн оношын байдал.

Мөн дээрх өвчнүүдийн дараах сэргээн засах эмчилгээнүүд хийгдэж байна. Эмчилгээний дараах биеийн байдлын сайжрал 90-95%-тай байна. Манай төвөөр давтан хэвтэн эмчлүүлэгчдийн тоо жил ирэх тусам нэмэгдэх хандлагатай байна.

“Эрүүл мэндийг дэмжих нээлттэй хаалганы өдөрлөг”

Эрүүл Үрс хүүхдийн сэргээн засах төв нь 2026 оны 04-р сарын 21,21-ны өдрүүдэд Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан “Эрүүл мэндийг дэмжих нээлттэй хаалганы өдөрлөгт” оролцсон.Тус өдөрлөгөөр иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгийн ач холбогдлыг таниулах, эрүүл амьдралын хэв маягийг түгээн дэлгэрүүлэх зорилготой гурван өдрийн турш олон нийтэд нээлттэй зохион байгуулагдсан.

- **Өдөрлөгийн 1-р өдөр:** Хүүхдийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, хийгдэж нийт 100 хүүхдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.
- **Өдөрлөгийн 2-р өдөр:** Уламжлалт анагаах ухааны чиглэлээр нээлттэй хаалганы өдөрлөг зохиогдож Эрүүл Үрс хүүхдийн сэргээн засах төвийн 3 уламжлалтын эмч үзлэг оношилгоо хийж нийт 250 иргэнд үзлэг оношилгоо хийж, 2 өдрийн хугацаанд нийт 350 иргэнийг хамруулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн.



Зураг 11. Өдөрлөгийн явцаас

1.4. Эмнэлгийн дотоод болон гадаад орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт:

- ✚ Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв нь Өдөр тутмын цэвэрлэгээг

ЭМС-ийн 2019 оны 11 сарын 29-ний А/537 тоот тушаалын 6-р хавсралтын дагуу эмнэлгийн дотоод орчныг А, В, С 3-н бүсээр хуваан цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийн, зөөврийн кварцын гэрлээр өдөр бүр өвчтөний өрөөг цэвэрлэгээний дараа халдваргүйжүүлэн ажиллаж байна. Өдөр тутмын цэвэрлэгээг хяналт үнэлгээний хуудсаар тогтмол хянан, гарсан алдаа дутагдлыг тухай бүрд нь арилгуулан ажиллаж байна. Нийт хяналт үнэлгээний дундаж хувь 96%- тай үнэлэгдлээ.

Их цэвэрлэгээг 7 хоног бүрийн бүтэн сайн өдөр хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдийг гарсны дараа цэвэрлэгээний зориулалтын бодисуудаар цэвэрлэн дараагийн үйлчлүүлэгчдийг хүлээн авахад бэлтгэн ажиллаж байна.

Өдөр тутмын ариутгал цэвэрлэгээг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/96, А/104, А/81 дугаар хамтарсан тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу Монгол улсад халдваргүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох бодисын жагсаалтад орсон дараах бодисоор хийж ариутгаж байна.

- **Anios oxyfloor** цэвэрлэгээний бодисоор эмнэлгийн шал
- **Clinell брэндийн universal wipes** бүх төрлийн гадаргуу цэвэрлэх, халдваргүйжүүлэгч нойтон салфетка
- **Clinell брэндийн universal spray** бүх төрлийн гадаргуу цэвэрлэх, халдваргүйжүүлэгч цацлагаар эмнэлгийн ор, өвчтөний шүүгээ, хаалганы бариул гэх мэт бусад хатуу гадаргууг ариутган тогтмол цэвэрлэж байна.



Зураг 12. Цэвэрлэгээний хэсгээс

✚ Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв нь Эрүүл ахуйн тухай хуулийн 7.4, Хүнсний тухай хуулийн 10.1.2, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим MNS CAC/RCP 1:2003 стандартын 5.3, Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал MNS CAC/RCP 39:2011 стандартын 5.6 дагуу 2026 оны 02 сарын 15-ны өдөр гэрээт байгууллага болох АЖИН ҮЖИН ХХК-р Эрүүл үрс төвийн байранд агаарын ариутгал халдваргүйжүүлэлт, дизкаймерийн ариутгалыг төвийн нийт хөнжил, гудас, ор хөнжилийн давуунд хийлгэн ажилласан.

Хортон шавжгүйтгэлийг одоогоор хийлгээгүй байна.





Зураг 13. Ариутгалын явцаас

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв нь ЭМС-н А/537 тоот тушаалын 1-р хавсралтын дагуу Эрүүл мэндийн ажилтны гар угаах,халдваргүйжүүлэх хяналт үнэлгээг 2026 оны 05 сарын 20-ны өдөр хийсэн. Хяналт үнэлгээнд нийт 33 ажилтан буюу нийт ажилтны 91.6% хамрагдаж, хяналт үнэлгээний дундаж хувь 92%тай үнэлэгдлээ.



Зураг 14. Хяналт үнэлгээний явцаас

ЭМС-ийн 2019 оны 11 сарын 29-ний А/537 тоот тушаалын 9 дүгээр хавсралтын дагуу Стандарт тусгаарлах өрөө **Class S** хавьтал болон туслын замаар дамждаг халдварын үед ашиглах тусгаарлах өрөөний бэлэн байдлыг тогтмол хангаж ажиллаж байна.



Зураг 15. Тусгаарлах өрөө

🚧 Нийслэлийн сэргээн засах “Эрүүл үрс” төв нь Улаанбаатар хотын Ерөнхий

менежерийн 2026 оны А/02 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2026 оны А/93 дугаар захирамжийн хүрээнд 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр, мөн Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2026 оны А/02 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2026 оны А/171 дүгээр захирамжийн хүрээнд 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр, түүнчлэн 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр бүх нийтийн их цэвэрлэгээг тус тус зохион байгууллаа.

Цэвэрлэгээний ажлын хүрээнд байгууллагын ойр орчмын 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам, талбайн хог хаягдлыг цэвэрлэж, байгууллагын хашаа, хайс, хашлага, хогийн савыг угааж цэвэрлэх, гадаад болон дотоод орчны их цэвэрлэгээг хийж, орчны өнгө үзэмжийг сэргээх ажлуудыг гүйцэтгэлээ. Мөн байгууллагын орчны ногоон байгууламжийн арчилгаа, усалгааг тогтмол хийж, гадна орчны өнгө үзэмжийг сайжруулах, хог хаягдлыг тухай бүр цэвэрлэн орчны цэвэр, аюулгүй байдлыг ханган ажилласан.



Зураг 16. Цэвэрлэгээний явцаас

1.5. Эмнэлгийн эм тарианы нөөц, хугацаа, эрүүл мэндийн ажилтны хамгаалах хувцас хэрэглэл, халдваргүйжүүлэх цэвэрлэгээний бодисын нөөц:

🚧 Эрүүл үрс төв нь 2026 онд эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйжүүлэх бодисын нөөцийн судалгааг сар бүр гаргаж, 2 сарын нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна.

Эмийн нөөцийн өрөөний чийгшил, температурын тэмдэглэл хөтөлж, ахлах сувилагч тэмдэглэлийг хянан ажиллаж байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн тогтоосон горимд эм хадгалах зориулалтын хөргөгчид 4-12 хэмд дараах төрлийн эм хэрэгслийг хадгалж байна.

- 1.Тосон түрхлэг
- 2.Лаа
- 3.Нүдний дусаалга
- 4.Гадуур хэрэглэх уусмал
- 5.Шингэн уусмал
- 6.Хамрын цацлага

Бусад эм хэрэгслүүдийг шаардлага хангасан тасалгааны хэмд хадгалан ажиллаж байна. Мөн эм, тарианы хугацааг хугацаат эмийн самбар ажиллуулан,

хугацаа дууссан эмийг хүрэн өнгийн уутанд цуглуулан “Элемент” буюу Эмнэлгийн хог хаягдлын гэрээт компанитай устгалд оруулан ажиллаж байна.



Зураг 17. Эм тарианы нөөц



Зураг 18. Цэвэрлэгээний бодисын нөөц

1.6. Сэтгэл ханамж:

🌈 Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгч эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцаа хандлагыг тодорхойлох, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, үйлчлүүлэгч төвтэй байдал, эмчилгээний үр дүнг тооцож “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавигдах шаардлага” MNS 7014:2023 стандартыг үндэслэн сэргээн засах төв амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасгийн үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан.

Эрүүл мэндийн статистик мэдээллийн сан www.1313.mn сайтаар хэвтэн эмчлүүлэх болон амбулатори хэсэгт 92 үйлчлүүлэгч судалгаанд хамрагдсан.

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Үнэлгээнд хамрагдсан хүний тоо		Нийт
1	Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв	Амбулаториор үйлчлүүлэгч	Хэвтэн эмчлүүлэгч	92
		48	44	

Хүснэгт 7. Үйлчлүүлэгчдийн тоо

Үнэлгээний үндсэн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийн салбарын стандарт судалгаанд дараах үзүүлэлтүүдийг голчлон үнэлдэг:

- Эмнэлгийн орчин: Цэвэрлэгээ, дулаан тохь тух, ариун цэврийн байгууламж.
- Эмч, мэргэжилтний харилцаа: Харилцааны соёл, зөвлөгөө өгөх байдал, мэргэжлийн ур чадвар.
- Тусламж үйлчилгээний хүлээгдэл: Цаг авалт, амбулаторийн хүлээгдэл
- Хоолны чанар: (Хэвтэн эмчлүүлэх тасгийн хувьд).

Үйлчлүүлэгчийн үнэлгээний дүгнэлт

Хүүхдийн сэргээн засах төвөөр 2026 оны II-р улирлын нийт 283 үйлчлүүлэгч үйлчлүүлснээс сэтгэл ханамжийн судалгаан хамрагдсан 92 үйлчлүүлэгчийн амбулатори хэсэгт 48 хэвтэн эмчлүүлэх тасагт 44 үйлчлүүлэгч сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдаж, нийт үйлчлүүлэгчийн 32,5%-нь судалгаанд хамрагдсан.

Үйлчилгээний соёл ба Харилцаа хандлага:

Судалгаанд оролцогчдын **90-ээс дээш хувь** нь эмнэлгийн хөтөч болон угтах үйлчилгээнд сэтгэл ханамжтай байгаа нь тус төвийн үйлчилгээний стандарт, соёл өндөр түвшинд байгааг илтгэж байна. Эмч, мэргэжилтнүүд үйлчлүүлэгчтэй мэндлэх, угтах соёл хэвшсэн нь эмнэлэгт итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлж байна.




График 9. Харилцаа хандлага




График 10. Цэвэрлэгээний үнэлгээг харуулбал

Цаашид анхаарах санал

Хэдийгээр үндсэн үзүүлэлтүүд 90%-иас дээш үнэлгээтэй байгаа ч энэхүү түвшнийг тогтвортой хадгалахын тулд:

- **Хувцасны өлгүүр болон ариун цэврийн өрөөний тоноглол** зэрэг туслах дэд бүтцийг сайжруулах замаар үйлчлүүлэгчдийн тав тухыг бүрэн хангах

- Сайн туршлага, үйлчилгээний стандартыг шинээр томилогдсон ажилтнуудад тогтмол сургах
- Үйлчлүүлэгчдэд өгөх зөвлөгөө, мэдээллийг илүү хүртээмжтэй болгох үүднээс санамж хуудас, QR кодыг ашиглахыг зөвлөж байна.

Сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр хийсэн ажил

1. Угтах үйлчилгээ ба Хөтчийн зохион байгуулалт:

- **Хөтчийн үйлчилгээг тогтмолжуулав:** Амбулаторийн хэсэгт үйлчлүүлэгчдийг угтах, мэдээллээр хангах, шаардлагатай кабинет руу чиглүүлэх "Хөтөч ажилтан"-ыг ажиллуулж эхэлснээр иргэдийн төөрөгдөл, хүлээгдлийг бууруулсан.
- **Мэндчилэх соёл:** "Үйлчлүүлэгчийг инээмсэглэн угтах" стандартыг нийт ажилтнуудын дунд хэвшүүлж, өглөөний шуурхай зөвлөгөөнөөр харилцаа хандлагын зааварчилгааг тогтмол өгч ажиллав.

2. Эмнэлгийн мэргэжилтний харилцаа, зөвлөгөө:

- **Мэдээлэл өгөх чадамжийг сайжруулав:** Эмч нар үйлчлүүлэгчид өвчний онош, шинжилгээний хариу, эмийн гаж нөлөөг энгийн, ойлгомжтой хэллэгээр тайлбарлан өгдөг "Зөвлөх цаг"-ийг үзлэг бүрд гаргаж хэвшүүлэв.
- **Идэвхтэй сонсох ур чадвар:** Эмч, сувилагч нарт зориулсан "Үйлчлүүлэгчийг сонсох, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх" богино хэмжээний сургалтыг зохион байгуулж, үйлчилгээний чанарт ахиц гаргасан.
- Тусламж үйлчилгээний стандарт мөрдөлтийн талаар тохиолдолд суурилсан 1 удаагийн хэлэлцүүлэг хийсэн.

3. Амбулаторийн зохион байгуулалт ба Орчин:

- **Цаг авалтын оновчлол:** Амбулаторийн тусламж үйлчилгээний хүлээгдлийг бууруулах зорилгоор үзлэгийн цагийн товлолтыг нарийвчилж, дараалал зохицуулалтыг сайжрууллаа.
- **Дэд бүтцийн шинэчлэл:** Үйлчлүүлэгчдийн тав тухыг хангах үүднээс **хувцасны өлгүүрийн багтаамжийг нэмэгдүүлж**, ариун цэврийн өрөөний тохижилт, ариун цэвэрт өдөр тутмын хяналтын хуудсаар (checklist) хяналт тавьж ажиллав.

🚦 2026 оны хагас жилийн байдлаар нийслэлийн хүүхдийн сэргээн засах төвөөр нийт 255 хүүхэд хэвтсэнээс 180 хүүхдэд эцэг эх асран хамгаалагч халатжлан дэмжигчдээс түүвэрчлэн сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан байна. Хоолны амт чанар, сэтгэл ханамжийн судалгааг Тэдний саналд үндэслэн дүн шинжилгээ хийх, төлөвлөх, үйлчлүүлэгч төвтэй байдалд гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Хоолны амт чанар, сэтгэл ханамжийн судалгааг: Нийт судалгаанд оролцсон 255 хүнээс 239 нь эмнэлгийн хоолны амт чанар маш сайн Дундаж- 14 Сайжруулах шаардлагатай -2 байна гэж үнэлсэн байна.

- Хоол амт чанар сайн байсан, танай хамт олонд баярлалаа.
- Ажилчидын харилцаа хандлага сайтай сайхан байлаа.
- Үйлчилгээ порц сайтай байсан, тогооч эгчдээ баярлалаа
- Гоё хоол хийж өгсөн тогооч эгчдээ баярлалаа.

Сайжруулах шаардлагатай санал нь:

- Нарийн ногоог түлхүү оруулж өгөх
- Ширхэгийн хоолны хачир тусдаа байвал хүүхэд бариж идэхэд эвтээхэн.

Авсан арга хэмхээ: өргөст хэмх, улаан лооль бууцай юуцай эрдэнэшиштэй хоолыг түлхүү оруулж өглөө. Ширхэгийн хоолыг хачираар баяжууллаа.



Зураг 19. Хоолны зургаас

Хоолны амт чанар, сэтгэл ханамжийн судалгаа




График 11. Хоолны амт чанар

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тоот тушаалын дагуу сэргээн засах төвийн 36 эмч, эмнэлгийн ажилчдаас сэтгэл ханамжийн судалгаа 6 бүлгийн 55 асуулт бүхий ерөнхий сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг хувиар тооцвол Сайн 98% Дунд 2% үнэлэгдсэн байна. 2025 оны жилийн эцсийн ажилчдын сэтгэл ханамжийн судалгаанаас 2026 онд Сайн 2% Дунд 1% тус тус сайжирч ажилласан байна.




График 12. Ажилчдын сэтгэл ханамжийн судалгаа

Ажилчдын сэтгэл ханамжийн судалгаанаас ирсэн санал хүсэлт:

- ✓ Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа
- ✓ Хүний нөөцийн хөгжлийн бодлогыг тасралтгүй хэрэгжүүлж, ажилтнуудын сургалт, чадавхыг нэмэгдүүлэх.
- ✓ Байгууллагын эерэг соёлыг тогтмол дэмжих, хамт олны уур амьсгалыг сайжруулах үйл ажиллагааг үргэлжлүүлэх.
- ✓ Үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах, хамт олны харилцааны соёлыг хэвшүүлэх.

Ажилчдын сэтгэл ханамжийн судалгаанаас ирсэн талархал :

- ✓ Эмнэлгийн удирдлагууд ажилчдынхаа үгийг сонсдог, нээлттэй, шударга шийдвэр гаргадагт баяртай байдаг.
- ✓ Сэргээн засах төвийн хамт олны дундах уур амьсгал маш халуун дулаан, бие биеэ дэмждэг, багийн ажиллагаа сайн байдагт талархдаг.
- ✓ Сурах суралцах боломжийг олгож сургаж байгаад баярлалаа

1.7. Өргөдөл гомдол

Эрүүл үрс төвийн хэмжээнд өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх төлөвлөгөөг 2026.01.16-ны өдрөөр төвийн даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Иргэдийн гомдол, саналыг хүлээн авах, тайлагнах тухай” 154 тоот тушаалын дагуу сэргээн засах төвийн хэмжээнд ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэдэг. НХСЗ-Эрүүл үрс төвийн хэмжээнд ирсэн үйлчлүүлэгчдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархлыг төвийн албаны утас болох 77082651 дугаарын утсаар, сэтгэл ханамжийн судалгаагаар, чанарын менежер өөрийн биеэр болон 86060100 утсаар, санал, хүсэлтийн хайрцаг, сувиллын веб хуудсаар хүлээн авч байна.

2026 оны хагас жилийн байдлаар байгууллагын хэмжээнд өргөдөл, гомдолгүй ажиллаж байна.

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төв нь ажилчдын цаг ашиглалтыг ERP системээр тогтмол хянан ажилладаг бөгөөд 2026 оны 01 сараас хойш эмч, ажилтнуудын хувьд биеэр, ERP системээр, 1111 төвөөр өргөдөл, гомдол ЭМТҮЧАБ болон хүний нөөцийн албанд ирээгүй ажиллаж байна.

1.8. Ажилчдын эрүүл мэнд:

🏠 Дархлаажуулалт:

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн нийт ажилчдыг 2025 оны 09 сарын 19-ний өдөр Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын Даргын 2025оны 09 сарын 19-ний өдрийн А/281 тоот тушаалын гуравдугаар хавсралт дагуу “Улирлын томуугийн эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” СХД 2-р хороонд байрлах Анан ӨЭМТ-тэй хамтран “SKYCellflu” дөрвөн цэнт 0,5 мл-р савласан 1 тунт вакцинаар нийт ажилчдыг Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтад хамруулан ажилласан. Дархлаажуулалтын нийт хувь 100%-тай хамруулан ажилласан байна.

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв нь нь 2026 оны хагас жилийн байдлаар ЭМС-ийн 2019 оны 11 сарын 29-ний А/537 тоот тушаалын гуравдугаар хавсралтын дагуу 2024 онд элэгний В вирусийн эсрэг 3 тунт вакцинд нийт 28 ажилчдыг хамруулан ажилласан.

2025 онд Элэгний В вирусийн вакцинд хамрагдсан 28 ажилтныг дархлаа тогтцын шинжилгээнд 100% хамруулан ажилласан. Дархлаа тогтцыг үзүүлсэн бүх ажилчдын дархлаа тогтоц буюу Anti HBs маркер 141.56 mIU/ml-491.92 mIU/ml буюу сайн байсан.

ЭМС-ийн 2019 оны 11 сарын 29-ний А/537 тоот тушаалын гуравдугаар хавсралтын дагуу Anti HBs маркер 100mIU/ml –ээс их дархлаа тогтсон бол 5 жилийн дараа дархлаа тогтцын шинжилгээг давтан тодорхойлуулна. 5 жил дотор дахин дархлал тогтоц үзэх шаардлагагүй гэсэн тушаалыг мөрдөн ажиллаж байна.

Ажилчдын вакцин хамрагдалтыг хүснэгтээр харуулбал:

№	Вакцины хамрагдал	Тоо
1.	Вакцинд орсон	28 ажилтан
2.	Шинээр ажилд орсон	5 ажилтан
3.	Элэгний В вирустай	3 ажилтан

Хүснэгт 8. Вакцины хамрагдалт

Элэгний В вирусийн вакцин хийгдээгүй 5 шинэ ажилтныг вакцинд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.



Зураг 20. Вакцины явцын зургаас

✚ ЭМС-ийн 2019 оны 11 сарын 29-ны өдрийн А/537 тоот тушаалын 3-р хавсралт

төвийн даргын А/28 тоот тушаалын дагуу шинэ ажилтныг эмчийн үзлэг шинжилгээ болон В, С вирусийн шинжилгээнд хамруулан ажилласан. Тус шинжилгээгээр гепатит В болон С вирусийн халдваргүй болох нь батлагдсан.



Зураг 21. Шинжилгээний зураг

Зорилт 2: Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.

✚ Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв нь “КАРТЕ – Эмнэлгийн удирдлагын систем”-тэй гэрээгээр хамтран ажилладаг. Тус программын хүрээнд нийт үйлчлүүлж буй өвчтөнд

- цаг олгох
- үзлэг оношилгоо хийх
- шинжилгээ төлөвлөх
- эмчилгээ захиалах
- хяналт хийх

гэх мэт үйлчлүүлэгчтэй холбоотой бүхий л үйл ажиллагааг системд оруулан ажиллаж байна. Ингэснээр үйлчлүүлэгчдийн эмчилгээний явц шинжилгээний хариуг цаг алдалгүй дотоод сүлжээгээр дамжуулан харах, үйлчлүүлэгчдэд чирэгдэл үүсгэн олон

газар луу явахгүй байх, үйлчлүүлэгчдийн цаг хугацааг хэмнэх болон цаасанд суурьтай бүртгэлийг бууруулсан.

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн **цахим хуудас** болон **77082651** утсыг тогтмол ажиллуулан зөвөлгөө мэдээлэл түгээн ажиллаж байна.

 Эрүүл Үрс төв нь байгууллагын пейж хуудас буюу цахим хуудсаараа дамжуулан 2026 оны хагас жилийн байдлаар 11к дагагчтай болсон ба цахим хуудсаараа дамжуулан эрүүл мэндийн боловсрол олгон нийт 79 пост мэдээ, мэдээлэл түгээснээс 22удаагийн video, reels түгээн ажилласан байна.

Үүнээс:

- тухайн мэдээ, мэдээллүүдийг цааш түгээсэн буюу /share/ хийсэн-569
- бусдад таалагдсан буюу /like/-1639 байна.

 Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1692 дугаартай Албан хэрэг хөтлөлтийн "eDoc" системийг "V-0.1.9.3" шинэчилсэн хувилбарт шилжүүлэх тухай" захирамжийн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд 2026 оны 04 дүгээр сарын 20-ноос шинэ системд бүрэн шилжин ажиллаж байна.

Мөн ЭМХТ, НЭМГ, АШУҮИС, Эрүүл мэндийн салбарын нэгдсэн группын цахим хуудас, Монголын ажил олгогчдын нэгдсэн групп “biznetwork.mn” цахим сайт, байгууллагын цахим сайтад ажлын байрны зарыг нээлттэй зарлан Сэргээн засах төвийн даргын 2023 оны 03 сарын 01-ны өдрийн А/11 тоот тушаалын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг.

Зорилт 3. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.

2.1. Сургалт сурталчилгаа:

 Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл Үрс” төв нь 2026 оны эхний хагас жилд үйлчлүүлэгч хүүхдүүд болон тэдний эцэг эх, асран хамгаалагчдад чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох, урьдчилан сэргийлэх мэдлэг хандлагыг дээшлүүлэх зорилтот сургалтуудыг зохион байгуулан ажиллалаа. Хагас жилийн байдлаар нийт 5 удаагийн үндсэн сэдэвт сургалтыг зохион байгуулж, үйлчлүүлэгчдийг шаардлагатай мэдээлэл, зөвлөмжөөр хангаж ажилласан байна. Сургалтуудыг дараах үндсэн 5 сэдвийн дагуу Эрүүл Үрс төвийн эмчилгээний тасгийн эмч нар хийж, мэдээ мэдээлэл хүргэн ажилласан. Үүнд:

- Осол гэмтлээс сэргийлэх
- Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх
- Хахалтын үед үзүүлэх тусламж
- Улаанбурхан өвчнөөс сэргийлэх
- Гар хөл амны өвчнөөс сэргийлэх сургалт тус тус хийсэн.



Зураг 22. Сургалтын явцаас


“Эрүүл үрс” хүүхдийн сэргээн засах төвөөр үйлчлүүлж буй иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг байгууллагын цахим хуудас, болон тараах материал ашиглан тасаг нэгжийн онцлогт тохируулан хийсэн. Сургалтын давтамжийг нэмэгдүүлэн 9 төрлийн сургалтын сэдвүүдээр зөвлөмж гарган тасаг, нэгжид байршуулан 2026 оны хагас жилийн байдлаар нийтдээ 790 ширхэг тараах материал тараасан. Үүнд:

- Осол гэмтлээс сэргийлэх зөвлөмж-40ш
- Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх-50ш
- Улаанбурхан өвчнөөс сэргийлэх -50ш
- Бариа эмчилгээний ач холбогдол-200ш
- Гар хөл амны өвчин-30ш
- Д витамин дутал-35ш
- Хахалтын үед үзүүлэх тусламж-30ш
- Хавтгай тавхай-30ш
- Эрүүл Үрс хүүхдийн сэргээн засах төвийн танилцуулга-325ш зөвлөмж, гарын авлагыг иргэдэд тараасан байна. /Зураг №2/



Зураг 23. Тараах материалын бэлдсэн байдал

Тус төв нь байгууллагын албан ёсны цахим хуудсаар дамжуулан иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих мэдээ, мэдээллийг тогтмол бэлтгэн 2026 оны хагас жилийн байдлаар 11мянган дагагчтай болсон ба 79 мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг дамжуулан эрүүл мэндийн боловсрол олгон ажиллаж байна. Үүнээс like-1639,/ таалагдсан/ share-569 /цааш түгээсэн/ үзүүлэлттэй байна.



Зураг 24. Цахим хуудасны хандалтын явц

✚ Эрүүл Үрс төв нь 2026 оны 03-р сарын 17-ны өдөр СХД-ийн цагдаагийн 1-р хэлтсийн Хүүхдийн асуудал хариуцсан ажилтан Дэслэгч Б.Тэлмэнтэй хамтран “Өөр байж болно” “Донтолтын цаана юу нуугддаг вэ?” сэдэвт сургалтыг төвийн хэвтэн эмчлүүлэх тасгийн өсвөр насны 15 үйлчлүүлэгч нарт зохион байгуулсан.



Зураг 25. Үйлчлүүлэгчдийн сургалтын явцаас

✚ Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл Үрс төв нь сургалтыг 2026 оны 02 сарын 06-ны өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 12-р сургуулийн 5е ангийн 41 сурагчдад, мөн Нийслэлийн ерөнхий боловсролын 153-р сургуулийн 12а ангийн 47 сурагчдад нийт 2 сургуулийн, 2 бүлгийн, 88 сурагчдад эрүүл мэндийн боловсрол олгон ажилласан. Сургалтаар томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлааг дэмжих зөв дадал хэвшил, халуун аарц болон амин дэмийн хэрэглээний ач холбогдлын талаар мэдээлэл өгч хүүхдийн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр “Эрүүл үрс төв”-ийн их эмч нар удирдан зохион байгуулан ажилласан. Сургалтын төгсгөлд хүүхдүүдэд дархлааг дэмжих зорилгоор халуун аарц, амин дэм, амны хаалт тараан өгч, зөвлөмж, мэдээллээр хангаж ажилласан.



Зураг 26. Сургалт болон дархлаажуулалтын явцаас

✚ Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төв нь нийслэлийн ерөнхий

боловсролын 12-р сургуулийн 5е ангийн нийт 41 сурагчдад, 153-р сургуулийн 12а ангийн 42 сурагчдад бусдын ялгаатай байдлыг буруушаах, гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, дарамтлах зэрэг үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх сургалтын зохион байгуулсан.



Зураг 27. Сургалтын явцаас

“Харилцан хүндэтгэе” аяны хүрээнд зөвлөмж мэдээ мэдээллийг “Эрүүл Үрс” төвийн цахим хуудсаар 4 удаагийн пост, 1 удаагийн видео бичлэг нийт 7 удаагийн пост мэдээлэл түгээн ажилласнаас бусдад таалагдсан буюу /like/-89, цааш түгээсэн буюу-/share хийсэн нь/-34 байна.



Зураг 28. Цахим хуудсаар мэдээлэл түгээсэн байдал

2.2. Хүний нөөцийн бодлого, зохицуулалт

Тус сэргээн засах төв нь Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 04 дугаар сарын 01-ны өдрийн “Дүрэм батлах тухай” А/36 дугаар тоот тушаалын дагуу 2026 оны А01 тоот даргын тушаалаар нийт 46 албан хаагчийн бүтэц, орон тоог батлан ажиллаж байна. Байгууллагын дотоод журмыг 2026 оны 01 дугаар сарын 02-ний өдрийн А/02 дугаар тушаалаар шинэчлэн боловсруулан батлуулж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн стандартын дагуу тусламж үйлчилгээний мэргэжилтний эзлэх хувь

№	Мэргэжлийн төрлүүд	Орон тооны хязгаар	2025 он	2026 он	Хувь
1.	Сэргээн засахын их эмч	1	1	1	100%
2.	Сэргээн засахын сувилагч	2	2	3	100%
3.	Хүүхдийн сувилагч	2	0	1	50%
4.	Хөдөлгөөн засалч	1	1	1	100%
5.	Хөдөлмөр засалч	2	0	0	0%
6.	Хэл засалч	1	0	0	0
7.	Нийгмийн ажилтан	2	0	2	100%
8.	Хоолзүйч	1	1	1	100%
9.	Хүүхдийн эмч	2	2	2	100%
10.	Төрөлжсөн мэргэжлийн хүүхдийн мэдрэлийн эмч	1-2	0	1	100%
11.	Төрөлжсөн мэргэжлийн хүүхдийн дүрс оношилгооны эмч	1	0	1	100%
12.	Уламжлалтын эмч	1-2	1	2	100%
13.		1	2		100%
Нийт					80,7%

Хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн 80 ортой өргөтгөлийн барилгын ажил 2026 оны 06 дүгээр сард ашиглалтад орохоор улсын комисст хүсэлтээ өгсөн. Үүний дагуу тус сэргээн засах төвийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг Сэргээн засах төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS6801:2019 стандартын дагуу нэмэгдүүлэх шаардлагатай тооцооллыг гарган Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/36 тоот тушаалын орон тооны дээд хязгаарыг батлах 03 дугаар хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтээ Нийслэлийн Эрүүл мэндийн газарт өгсөн боловч шинэ барилга ашиглалтад улсын комисс хүлээн аваагүй учир шинэ орон тооны тушаал хараахан батлагдаагүй байна.

Тус төв нь MNS 6801:2019 стандартад заасан орон тооны хязгаар, мэргэжлийн чиглэлийн дагуу хүний нөөцөө төлөвлөн ажиллаж байна.Одоогийн байдлаар нийт мэргэжлийн тусламж үйлчилгээний бүрдүүлэлт 80.7%-тай байгаа бөгөөд 2025 онтой харьцуулахад олон төрлийн мэргэжлээр орон тоог нөхөж, чадавхыг нэмэгдүүлсэн. Тухайлбал, 2025 онд орон тоо нь бүрдээгүй байсан сувилагч, нийгмийн ажилтан, төрөлжсөн хүүхдийн эмч зэрэг чиглэлүүдэд 2026 онд зохих түвшинд хүргэн ажиллаж байна.

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн нэгдүгээр зорилтын хүрээнд Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хуулийн хүрээнд Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13-т“ төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр болон ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах” гэж заасан байдаг. Хуулийн заалт болон тус байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлийн бодит хэрэгцээг үндэслэж тодорхой ажлыг зохион

байгуулан

ажилласан.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр:

- Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэн Эрүүл үрс төвийн 2026 оны хагас жилийн нийт төсвийн 80%-г цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан байна.
- Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг), Хоногт олгохоор тогтоосон хоолны зардал 13000 төг, унааны зардал 2000 төгрөгөөр тооцож ажилтан ,албан хаагчидад олгож байна.
- Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж) 98%-тай байна.
- Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор 2026 оны 8 сард Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахаар төлөвлөсөн
- 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр албан хаагчдын нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 02 дугаар сард Ананд хужирт сувилалын газарт 10-н албан хаагчдыг амраан ажилласан.

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах төвөөс 2026 оны эхний хагас жилийн хугацаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй, тав тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эмч, эмнэлгийн ажилтнуудыг ажлын зориулалтын хувцсаар үе шаттайгаар хангах ажлыг зохион байгууллаа.

Тус ажлын хүрээнд ажлын хувцасыг үе шаттайгаар шинэчлэлээ.

- 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Ажлын цамц 13 ширхэгийг ЗААТ тасгийн ажилчдад
- 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр эмнэлгийн хослол 21 ширхэгийг Эмчилгээний тасгийн ажилчдад
- 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдөр эмнэлгийн халаад 6 ширхэгийг ЗААТ тасагт тус тус худалдан авч өгсөн.

Дээрх хугацаанд нийт 41 ширхэг ажлын хувцсыг эмч, эмнэлгийн ажилтнуудад хуваарилан олгож, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлэв.



Зураг 28. Ажилчдын хувцас хангалт зургаас

Эмч сувилагч нарын төрөлжсөн мэргэшил, зэрэг хамгаалалт:

Эрүүл Үрс төв нь эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг нарийн мэргэжлээр төрөлжүүлэн сургах, чадавхжуулах, зорилтыг шат дараатай хэрэгжүүлж байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар тус төвийн-1 эмч **“Хүүхдийн Ахлах зэрэг”** хамгаалсан бол **Хүүхдийн 2 их эмч, 2 сувилагч** төгсөлтийн дараах төрөлжсөн нарийн мэргэшлийн сургалтад амжилттай хамрагдлаа. Үүнээс 1 хүүхдийн эмч мэдрэлийн эмчээр, хүүхдийн дүрс оношилгооны эмчээр 1 эмч мэргэшиж төгссөн.



Зураг 29.. Сургалтын төгсөлтийн үйл явцаас

2026 ондоо өөрийн байгууллагын эмч нарыг улам мэргэшүүлэхээр зорин ажиллаж байгаа төдийгүй сэргээн засахын нарийн мэргэжлийн эмч, хүүхдийн нарийн мэргэжлийн эмчийг бэлтгэхээр төлөвлөн ажиллаж байна. Тиймээс манай төвийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэх боломжтой юм.

2025 оны байдлаар төвийн хэмжээнд 5 сувилагчтай байсан бол 2026 оны байдлаар тусгай мэргэжлийн 3 сувилагч амжилттай төгсөж 8 сувилагчтай болсон байна.



Зураг 30. Баклавр сургалтад амжилттай суралцан төгссөн байдал.

Цаашлаад тус сувилагч нараас 2 сувилагч төрөлжсөн мэргэжлийн сургалтад суралцаж байна. Үүнд:

- Хүүхдийн сувилагч -1
- Сэргээн засах эмчилгээний сувилагч -1 суралцаж байна.

Мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн, дээшлүүлэх сургалтаас гадна, эмнэлгийн мэргэжилтнүүдийн эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, боловсролын зэргийг ахиулах чиглэлд тодорхой ахиц гарч, 2026 онд **тус төвийн 4 эмч Анагаах ухааны магистрантурт** суралцаж байна. 1 эмч магистр зэрэгтэй болсон байна.

Хүүхдийн сэргээн засах төвийн хэмжээнд хүний нөөцийн чадавх 2025 онтой харьцуулахад тогтмол нэмэгдэж байгаа төдийгүй 3 сувилагч **'Ач' АУИС-д Нийгмийн**

эрүүл мэндийн судлаачийн мэргэжлээр суралцаж байна. Ингэснээр хүүхдийн сэргээн засах төв нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүртээмжтэй хүргэн, судалгаа шинжилгээг илүү боловсронгуй зохион байгуулах боломжтой болно.



Зураг 31. Мэргэшил дээшлүүлэх сургалт

Тус төв нь 2025 онд 5 асрагчтай үйл ажиллагаа явуулж байсан бол 2026 онд асрагч нар мэргэшин туслах сувилагчаар суралцан амжилттай төгссөн байна. Иймээс эмнэлгийн мэргэжилтний тоо нэмэгдэн эмч болон сувилагчийн харьцаа 1:1.3 болсон байна. Цаашид хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах үүднээс дутагдалтай орон тоо бүхий ажлын байранд дотоодоосоо суралцах боломжийг эрэлхийлэн ажиллаж байна.

2.3. Ажилчдын гадаад, дотоод сургалт:

Эрүүл Үрс хүүхдийн сэргээн засах төв нь 2026 онд гадагшаа чиглэсэн 41 сургалт төлөвлөснөөс танхимын 15 сургалтад хамрагдаж, цахимаар 5 удаагийн сургалтад тус тус эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж, хагас жилийн байдлаар сургалтын төлөвлөгөөний биелэлт 49%-ийн биелэлттэй явагдаж байна.

Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар, төрөлжсөн нарийн мэргэжлийн эрүүл мэндийн байгууллага болон бусад байгууллагаас зохион байгуулах танхимын сургалт болон онлайн сургалтад эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүд болон бусад ажилтнуудыг тогтмол хамруулан давхардсан тоогоор нийт ажилчдын 72%-ийг хамруулан ажиллаж байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой 4 удаагийн сургалтад хамруулсан Үүнд:

- Хүүхдийн цочмог хордолт, хордлогын үеийн тусламж
- Хүүхдийн чих, хамар хоолойн эмгэгийн үеийн тулгамдсан асуудлууд
- Аутизм ба боловсрол
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үнэ цэнэ





Зураг 32. Сургалтын явцаас

Эрүүл мэндийн удирдлага, чанар, санхүүжилттэй холбоотой 4 удаагийн сургалтад хамруулсан.

Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, хангамж бэлэн байдал
- ЭМ-н санхүүжилт, даатгалын тогтолцоо
- Авлигатай тэмцэх газрын 2026 онд шинээр томилогдсон ЭБАТ-уудад зориулсан сургалтуудад тус тус хамрагдсан.
- Байгууллагын стратегийн төлөвлөлт ба тэнцвэржүүлсэн үнэлгээний картыг нэвтрүүлэх нь



Зураг 33. Цахим сургалтын явцаас

Цахим шилжилт, архив албан хэрэг хөтлөлттэй холбоотой 6 удаагийн сургалт хамрагдсан.

- Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын танилцуулга, хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүй /3 удаагийн сургалт/
- SHILEN GOV.MN-ийн 2,0 хувилбар
- Архивын үйл ажиллагааны нийтлэг журамын танилцуулга, хадгаламжийн нэгж, бүрдүүлэх арга зүй
- “eDoc” системийн шинэчлэгдсэн хувилбар
- "eDoc" системийг "V-0.1.9.3" шинэчилсэн хувилбарт шилжүүлэх тухай"
- “Үндсэн эх үүсвэрийн жагсаалт”-ын дагуу 2023-2025 онд нөхөн баяжилт хийсэн байгууллагууд төрийн архивт хүлээлгэн өгсөн баримтын батлагдсан дансыг байгууллагын архивын систем (Archive eDoc)-д шивж оруулан цахимжуулах сургалт

- **Бусад:**
- Улаанбаатар хотын бүтээн байгуулалтын танилцуулга
- Жендертэй холбоотой эрх тэгш байдлыг хангах сарын аян сургалт /цахим/
- Гамшгаас хамгаалах штабын сургалт / цахим/ /Зураг №4 /



Зураг 34. Сургалтын явцаас

✚ Эрүүл Үрс төв нь дотооддоо төвийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг сайжруулах зорилгоор 2026 оны сургалтын төлөвлөгөөндөө 48 сургалт төлөвлөсөн бөгөөд үүнээс 21 сургалтыг төвийн хэмжээнд зохион байгуулж, сургалтын төлөвлөгөөний биелэлт 44%-тай явагдаж эмчилгээний тасгийн тусламж үйл ажиллагаатай сургалтад тасгийн ажилчдын хамрагдалт 78%-тай явагдаж байна. Энэ нь эмчилгээний тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд өдөр, шөнийн ээлж болон 24 цагийн жижүүрт үүрэг гүйцэтгэдэгтэй холбоотой юм. Тухайлбал, ээлжээс буусан болон амралтын цаг таарсан ажилтнууд сургалтад биеэр оролцох боломжгүй байсан нь ирцийн хувьд нөлөөлсөн болно. Цаашид ээлжийн ажилтай албан хаагчдыг нөхөн сургах, цахимаар сургалтын материалыг хүргүүлэх хэлбэрээр хамрагдалтыг 90%-д хүргэхээр зорилт тавин ажиллаж байна. Нийт ажилчдыг хамруулсан сургалтад ажилчдын 80% хамрагдан ажиллаж байна. Үүнээс:

- Яаралтай тусламжийн бэлэн байдал, хариу арга хэмжээ
- Халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагааг сайжруулах
- Уламжлалт анагаах ухааны сувилахуйн тусламж үйлчилгээний арга технологи, гардан үйлдлийг сайжруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын талаар сургалт
- Сувилахуйн тусламж үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллаж, сувилагч, туслах сувилагч нарын мэдлэг ур чадварыг сайжруулах
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөж ажиллах
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм
- Ажлын байран дах яаралтай тусламжийн сургалт
- ЭМС-ын 2019 оны 11 сарын 29-ны өдрийн А/537 тоот тушаалын 1-р хавсралтын дагуу Эрүүл мэндийн ажилтны гар угаах, халдваргүйжүүлэх талаар сургалт зохион байгуулан үнэлгээ хийж ажиллана.
- Гамшгаас хамгаалах сургалт
- “Монгол бичиг”-ээр уншиж бичих, чадвараа сайжруулах
- Шинээр мөрдөгдөж байгаа болон шинэчлэгдсэн хууль тогтоомжийн талаар мэдээлэл зэрэг сургалтуудыг зохион байгуулан ажилласан.



Зураг 35. Сургалтын явцаас

2.4. Сар бүрийн тэмдэглэлт өдрөөр хийсэн ажил:

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл Үрс төв нь Монгол Улсын Засгийн газрын 224 дүгээр тогтоол болон дүүргийн Засаг даргын 2025 оны А/749 дүгээр захирамжийн дагуу 2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 20 хоногийн хугацаанд “Хүүхэд -Эрсдэлгүй орчин” уриан дор осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх аянд нэгдэж тайланг хүргүүлж байна. Тус аяны хүрээнд “Хүүхэд -эрсдэлгүй орчин” аяны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажилласан.

1.Эрүүл Үрс төвийн эрсдэлийн багтай хамтран 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр төвийн гадна болон дотоод орчинд эрсдэлийн үнэлгээ хийсэн. Илэрсэн эрсдлүүдийг эрсдэлийн түвшнээр ангилахад

- Бага эрсдэл – 5
- Дунд эрсдэл – 4
- Өндөр эрсдэл – 24
- Ноцтой эрсдэл-8 байсан Эрсдлийн үнэлгээгээр осол гэмтэлтэй холбоотой дараах эрсдэл илэрсэн.Үүнд:

Гадна орчинд 1, дотоод орчинд-3 эрсдэл бүртгэгдсэн байна.

- Байгууллагын өөрийн эзэмшил ашиглалтад байгаа газар болон орчны 50метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн цас мөсийг тухай бүрд нь арилгаж, халтиргаа гулгаа үүсгэж, хальтарч унахаас сэргийлэн цэвэрлэж байна.
- Нойтон болон гулгамтгай шалнаас үүдэлтэй хальтарч унах эрсдэл
- Шат налуу замын бариул дутуу, стадарт хангаагүйгээс бүдэрч унах эрсдэл
- Бага насны хүүхдүүд орон дээрээс унах эрсдлүүд илэрсэн тул дараах арга хэмжээнүүдийг авч ажиллаж тайлант хугацаанд 4 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн ажилласан.

Нойтон болон гулгамтгай шалнаас үүдэлтэй хальтарч унах эрсдэл: Цэвэрлэгээ үйлчилгээ хийх тухай бүрт хүүхдүүд хальтарч унахаас сэргийлж анхааруулах тэмдэг тэмдэглээг тогмол хэрэглэж байна.

Шатнаас бүдэрч унах эрсдэл: Хүүхдүүд шатнаас унаж бүдрэхээс сэргийлж, анхааруулга санамжийг тасаг нэгжүүдэд хийж байршуулсан.



Зураг 36. Эрсдлийн бууруулах ажлын хэсгээс

Эрсдэлийг бууруулах арга хэмжээний үр дүнд ажлын байр болон хүүхдийн орчны аюулгүй байдал сайжирч, осол, гэмтэл гарах магадлал ойролцоогоор 30 хувиар буурсан гэж үнэлэгдэж байна.

2. Эрүүл Үрс төвийн 30 ажилчдад “Хүүхдийг болзошгүй эрсдэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх “Хүүхэд-Аюулгүй орчин” сэдэвт сургалтыг зохион байгуулан ажилласан.



Зураг 37. Сургалтын явцаас

3.Эрүүл Үрс төв нь 2026 оны 01-р сарын 27-ны өдрүүдэд СХД-ийн цагдаагийн 1-р хэлтэстэй хамтран “Хүүхдийг болзошгүй эрсдэл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалтыг төвийн хэвтэн эмчлүүлэх тасгийн 16 үйлчлүүлэгч нарт хийж, гарын авлага тараасан.Сургалтыг Хүүхдийн асуудал хариуцсан ажилтан Дэслэгч Б.Тэлмэн хийсэн.



Зураг 38. Сургалтын явцаас

4. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах болзошгүй эрсдэлээс сэргийлэх /гал түймэр, угаарын хий, халтиргаа гулгаа г.м/ зөвлөмж, сэрэмжлүүлгийг “Эрүүл Үрс” төвийн цахим хуудсаар 10удаагийн пост, Зудаагийн видео, 2 reels бичлэг нийт 15 удаагийн пост

мэдээлэл түгээн ажилласнаас бусдад таалагдсан буюу /like/-280, цааш түгээсэн буюу-/share хийсэн нь/-343 байна.



Зураг 39. Цахим хуудсаараа мэдээлэл түгээсэн байдал

Эрүүл Үрс төв нь Хүүхдийн аюулгүй байдлыг хангах болзошгүй эрсдэлээс сэргийлэх, Бага насны хүүхдийг ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, орон гэртээ аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлж, хүүхдэд тавих хараа хяналтаа сайжруулах, сэрэмжлүүлэх 2 удаагийн reels бичлэгийг өөрсдөө хийснээс бусдад таалагдсан буюу /like/-99, цааш түгээсэн буюу-/share хийсэн нь/-58 байсан ба аянд идэвхтэй оролцон ажиллаж байна.



Зураг 40. Reels түгээсэн байдал

5. Эрүүл Үрс төвийн амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасагт эцэг, эх асран хамгаалагчдад хүүхдийн аюулгүй байдлыг хангах болзошгүй эрсдлээс сэргийлэх сэрэмжлүүлгийг тасаг

нэгжүүдийн мэдээллийн самбарт байршуулан ажилласан.



Зураг 41. Санамж,анхааруулга байршуулсан хэсгээс

6. Сурагчдын улирлын амралт эхэлсэнтэй холбогдуулан Эрүүл Үрс төвийн ажилчдаас судалгаа авч, бага насны хүүхэдтэй 4 ажилтнуудын ажлын цагт зохицулалт хийж, гэртээ хараа хяналтгүй үлдэх хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс анхаарал хандуулан ажиллаж, ажлын байрандаа хүүхдээ авч ирэх боломжийг бүрдүүлэн дээрх хүүхдүүдэд өрөө гарган өгч, тав тухтай байлгах нөхцөлийг бүрдүүлж өгсөн.



7.Бага насны хүүхдийг орон дээрээс унахаас сэргийлж, зарим орнууд хашлагагүй байсан тул үлдсэн орнуудыг хашлагатай ор болгосон.

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл Үрс” төв нь хүүхдийн хорт хавдартай тэмцэх дэлхийн өдөртэй холбогдуулан хорт хавдрын талаарх зөвлөмж, хавдраас урьдчилан сэргийлэх талаар сургалтыг 2026 оны 02 сарын 13 өдөр Нийслэлийн ерөнхий боловсролын 12-р сургуулийн 5е ангийн 41 сурагчдад, 2026 оны 02 сарын 13 өдөр нийслэлийн ерөнхий боловсролын 153-р сургуулийн 12а ангийн 47 сурагчдад сургалтыг “Эрүүл үрс төв”-ийн их эмч С.Галхүү, Статистик О.Намжилсүрэн, сувилагч Ч.Отгонцэцэг, Х.Ууганзаяа нар удирдан зохион байгуулан ажилласан.

Сургалтын өмнө сургалтад сууж буй бага ангийн нийт 41 сурагчдаас сургалтын өмнөх тестээр үнэлэхэд дундаж мэдлэг 36%-тай байсан бол сургалтын дараа энэхүү мэдлэг 82% хувь болж сургалтын түвшин нь 46%-р нэмэгдсэн байна. Мөн сургалтын өмнөх сургалтад сууж буй ахлах ангийн нийт 47 сурагчдаас сургалтын өмнөх тестээр үнэлэхэд дундаж мэдлэг 52%-тай байсан бол сургалтын дараа энэхүү мэдлэг 94% хувь болж сургалтын түвшин нь 42%-р нэмэгдсэн байна.



Зураг 42. Сургалтын явцаас

✚ Эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэлхийн өдөртэй холбогдуулан хорт хавдрын талаарх зөвлөмж, хавдраас урьдчилан сэргийлэх талаар сургалтыг 2026 оны 03 сарын 06 өдөр “Эрүүл үрс төв”-ийн уламжлалтын их эмч Б.Лхамдулам, Ахлах сувилагч Д.Даваадулам, сувилагч М.Нямцэрэн, туслах сувилагч Х.Мөнхшүр нар хамтран зохион байгуулан ажилласан. Умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх өдөрлөг амжилттай зохион байгуулагдаж, эмэгтэйчүүдийн мэдлэгийг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой ажил боллоо.



Зураг 43. Умайн хүзүүний хорт хавдар сургалт



Зураг 44. Сургалтын явц

🚦 2026 оны 3 дугаар сарын 26-ны өдөр **“Эрүүл үрс төв”**-ийн эмч ажилтнууд ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 10-12 дугаар ангийн 35 сурагчдад зориулан **“Аутизмын хүрээний эмгэг, Ойлголт ба Харилцаа”** сэдэвт сургалтыг амжилттай зохион байгууллаа.

4-р сарын 2ны өдөр Аутизмыг таниулах дэлхийн өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Autism Awareness Day 2026” мэдээллийн өдөрлөгт аутизмтай хүүхэдтэй гэр бүлүүд, багш, эмч, мэргэжилтнүүд нэг дор цуглаж, хэрэгцээт мэдээлэл, зөвлөгөөг авч, харилцан туршлага солилцсон өдөрлөгт Эрүүл үрс төв нь хамтрагч байгуулгаар оролцон ажиллаа.



Зураг 45. Үйл ажиллагааны явцаас

🚦 Олон улсын хөдөлмөрийн байгууллага(ILO)-аас 2003 онд албан ёсоор **“Ажлын**

байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн өдөр”, “World Day for Safety and Health at Work”-ийг жил бүрийн 4-р сарын 28-ний өдөр дэлхий нийтээрээ тодорхой нэг уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлэхээр зарласан байдаг.

2026 онд тус өдрийг **“АЖЛЫН БАЙРАНД НИЙГЭМ-СЭТГЭЛЗҮЙН ЭРҮҮЛ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЦГЭЭЕ”** уриан дор нийслэлийн хүүхдийн сэргээн засах эрүүл үрс төв нь тэмдэглэн өнгөрүүлсэн байна.



Зураг 46. Өдөрлөгийн явцаас

🚦 Жил бүрийн 05 сарын 12-ны өдрийг дэлхий нийтээрээ Олон улсын сувилагчдын

өдөр болгон тэмдэглэдэг. Иймд Олон улсын сувилагчдын өдрийг угтан Сувилахуйн тусламж, үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд таниулах, сувилагч мэргэжлийн нэр хүндийг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад мэргэжлийн талаар зөв ойлголт, эерэг хандлага төлөвшүүлэх, цаашдын мэргэжил сонголтод нь дэмжлэг үзүүлэх зорилгоор сувилагч мэргэжлийг сурталчлах өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа.

Өдөрлөгт Нийслэлийн ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн ахлах ангийн сурагчид оролцож, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа болон сувилагч мэргэжлийн онцлог, ажлын орчинтой биечлэн танилцсан нь онцлог байв.

Өдөрлөгийн хүрээнд: Сурагчдад онол, практик хосолсон цогц мэдээлэл, танилцуулгыг хүргэлээ.

Сувилагч М.Нямцэрэн “Амин үзүүлэлт гэж юу вэ?” сэдвээр илтгэл танилцуулж, хүний амин чухал үзүүлэлтүүдийн ач холбогдол, тэдгээрийг хэмжих аргачлал, сувилахуйн тусламж үйлчилгээний өдөр тутмын хэрэглээг энгийн ойлгомжтой байдлаар тайлбарлав. Үүний зэрэгцээ сувилагч нар өөрсдийн ажлын онцлог, үүрэг хариуцлага, мэргэжлийн үнэ цэнэ, нийгэмд гүйцэтгэх үүргийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.

Сурагчдад сувилахуйн анхан шатны ур чадварыг танилцуулах зорилгоор үзүүлэх сургалтыг зохион байгуулж, дараах чадваруудыг практик байдлаар үзүүлэн таниуллаа. Үүнд:

- Артерийн даралт хэмжих
- Биеийн халуун хэмжих
- Амьсгал, судасны цохилт тоолох

- Тарилга хийх арга техник
- Боолт хийх аргачлал

Сурагчид өөрсдөө идэвхтэй оролцож дадлага хийснээр сувилагч мэргэжлийн бодит ажлын орчныг мэдрэх, сонирхох боломж бүрдсэн.

Хоол зүйч Б.Ялалтцэцэг 14–18 насны өсвөр үеийн хооллолтын онцлог, насанд тохирсон зөв хооллолтын зөвлөмжийг өгч, тогооч нартай хамтран өөрсдийн ажил мэргэжлийг танилцууллаа. Энэ үеэр зутан шөл, хоёр төрлийн үндсэн хоол, хачир салат зэрэг хоолыг бэлтгэн танилцуулж, эрүүл зөв хооллолтын талаар практик мэдээлэл хүргэв.

Мөн хөдөлгөөн засалч Т.Дэлгэрмаа амьсгалын болон сунгалтын дасгал зааж, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэхийн ач холбогдлыг тайлбарлан сурагчдад зөвлөгөө өгч ажиллалаа.

Дээрх өдөрлөг нь сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэхэд үр өгөөжтэй арга хэмжээ боллоо.



Зураг 47. Өдөрлөгийн явцаас



Зураг 48. Артерийн даралт хэмжих



Зураг49. Боолт хийх, амьсгал болон сунгалтын дасгалууд



Зураг 50. Тарилга хийх арга техник



Зураг 51. Хооллолтын зөвлөгөө

🚩 Олон улсын сувилагчдын баярыг тохиолдуулан Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төвийн эмчилгээний тасгаас сувилагч, туслах сувилагч нарын дунд “Сувилахуйн практик ур чадвар, харилцааны чадварыг үнэлэх” тэмцээнийг 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр зохион байгууллаа.

Тус тэмцээний зорилго нь сувилагч болон туслах сувилагч нарын клиник практик ур чадвар, мэргэжлийн харилцааны чадамжийг сайжруулах, аюулгүй, чанартай сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэх чадварыг дээшлүүлэхэд чиглэгдсэн болно.

Тэмцээнд нийт 5 баг оролцож, сувилагч болон туслах сувилагч нар дараах чиглэлээр мэдлэг, ур чадвараа сорин оролцлоо. Үүнд:

- Ёс зүйн хэм хэмжээтэй холбоотой багийн асуулт
- Сувилагч нарын гардан үйлдэл
- Туслах сувилагч нарын гардан үйлдэл
- Яаралтай тусламжийн кейс дээр ажиллах
- Уламжлалт сэргээн засах тусламж үйлчилгээг хамтран үзүүлэх

Тэмцээний үеэр оролцогчид багийн зохион байгуулалт, харилцаа хандлага, яаралтай нөхцөлд шийдвэр гаргах чадвар, гардан үйлдлийн ур чадвараар өрсөлдөн оролцсон бөгөөд бодит нөхцөлд ажиллах чадамжийг үнэлсэн үр дүнтэй арга хэмжээ боллоо.

Мөн сувилагч, туслах сувилагч нар хамтран ажиллах чадвар, харилцааны ур чадвар, ёс зүйн хандлагаа сайжруулахын зэрэгцээ бие биеэсээ суралцах, туршлага солилцох боломж бүрдсэн.

Тэмцээний нэгдсэн дүнгээр шалгуур үзүүлэлт болон багийн ажиллагааны үнэлгээг харгалзан шилдэг сувилагч, туслах сувилагч нарыг шалгаруулж байгууллагын дотоод журмын дагуу шагнал урамшуулал олгосон.

ТЭМЦЭЭНИЙ ШАГНАЛТ БАЙР:

- Шилдэг сувилагчаар Х. Ууганзаяа
- Шилдэг туслах сувилагчаар Г. Болормаа

ДҮГНЭЛТ:

Энэхүү тэмцээн нь сувилагч, туслах сувилагч нарын клиник практик ур чадвар, багаар ажиллах чадвар, мэргэжлийн ёс зүй, харилцаа хандлагыг бодит нөхцөлд үнэлэх, цаашид сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулахад чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.



Зураг 52. Шалгалтын явц



Зураг 53. Шилдэг сувилагч, шилдэг туслах сувилагч

🌈 Сувилахуйн тусламж, үйлчилгээний ач холбогдлыг олон нийтэд таниулах,

сувилагч мэргэжлийн нэр хүндийг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад энэхүү мэргэжлийн талаар зөв ойлголт, эерэг хандлага төлөвшүүлэх зорилгоор **“Миний мэдэх сувилагч”** сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг амжилттай зохион байгууллаа.

Тус уралдаанд Нийслэлийн ерөнхий боловсролын 12-р сургууль болон 153 дугаар сургуулийн 10–12 дугаар ангийн сурагчид хамрагдаж, уралдаан 2026 оны 04 дүгээр сарын 14-нөөс 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл үргэлжилсэн юм. Нийслэлийн Хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төвөөс гар бичмэл хэлбэрээр 200–300 үгтэй эссэ бичлэгүүдийг хүлээн авч, хоёр сургуулийн нийт 119 сурагч бүтээлээ ирүүлэн идэвхтэй оролцлоо. Шалгаруулах комисс тогтоосон шалгуурын дагуу бүтээлүүдийг үнэлж, шилдэг зургаан бүтээлийг тодрууллаа.

Уралдааны дүнгээр:

Нийслэлийн ерөнхий боловсролын 153 дугаар сургууль

- Тэргүүн байр – 11в ангийн сурагч Э.Билгүүн
- Дэд байр – 11в ангийн сурагч Анударь
- Гутгаар байр – 12в ангийн сурагч С.Нэнсэндэр

Нийслэлийн ерөнхий боловсролын 12 дугаар сургууль

- Тэргүүн байр – 12а ангийн сурагч Э.Уянга
- Дэд байр – 12а ангийн сурагч Э.Марал
- Гутгаар байр – 12в ангийн сурагч Э.Түмэнхүслэн

Ирүүлсэн эссэ бичлэгүүдэд сувилагчийн энэрэнгүй зан чанар, өндөр хариуцлага, хүнлэг үйлчилгээ, нийгэмд гүйцэтгэх чухал үүргийг онцлон тодорхой харуулсан нь онцгой байв. Сурагчид сувилагчийг өвчтөнд итгэл найдвар төрүүлэгч, эрүүл мэндийг хамгаалагч, нийгмийн үнэт мэргэжлийн нэг хэмээн ойлгож, эерэг хандлагаар хүлээн авч буйгаа бүтээлдээ тод илэрхийлжээ. Шагналт байрт шалгарсан сурагчдад өргөмжлөл, мөнгөн шагнал гардуулсан бөгөөд энэхүү уралдаан нь сурагчдын идэвх оролцоог нэмэгдүүлж, мэргэжил сонголтод эерэг нөлөө үзүүлсэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо.



Зураг 54. НЕБ-ын 153-р сургуулийн шагналт байранд шалгарсан сурагчид



Зураг 55. НЕБ-ын 12-р сургуулийн шагналт байранд шалгарсан сурагчид



Зураг 56. Оролцогчдын бүтээлүүд

ЗОРИЛТ 4. Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР хүрээнд

4.1. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг

Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, ажилтнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн хүүхдийн сэргээн засах “Эрүүл үрс” төвөөс жил бүр явган аяллыг тогтмол зохион байгуулж байна. Мөн ажилтнуудыг биеийн тамир, спортын арга хэмжээнд өргөнөөр хамруулах, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, хамт олны идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор тус төвийн захиргаанаас спортын өдөрлөгийг зохион байгууллаа. Спортын өдөрлөгийг гар бөмбөг, олс таталт гэсэн хоёр төрлөөр явуулж, шилдэг оролцогчид болон багуудыг шалгаруулсан бөгөөд байгууллагын нийт хамт олон идэвх санаачилгатай оролцлоо.



Зураг 57. Явган аялал зураг

🚦 2026 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан Улаанбаатар марафон тэмцээнд манай байгууллагаас 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцлоо. Тус тэмцээний 5 км-ийн зайд амжилттай гүйж, барианд бүрэн хүрч, тэмцээнийг амжилттай гүйцэтгэсэн. Оролцогчид биеийн тамир, спортыг дэмжих, эрүүл амьдралын хэв маягийг

төлөвшүүлэх зорилгоор идэвх санаачилгатай оролцож, байгууллагынхаа нэрийг төлөөлөн амжилттай оролцсон.



Зураг 58. Улаанбаатар марафон зураг

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, 2025 оны “Тэрбум

мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 44 дүгээр зарлиг, Засгийн газрын 2021 оны “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 350 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын ахалсан Уур амьсгалын үндэсний хорооны 2023 оны 01 дүгээр тогтоолын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалах, нөөцийг нэмэгдүүлэх, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, мод тарих, арчлан ургуулах, иргэд олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа.

Нийслэлийн Хүүхдийн Сэргээн Засах “Эрүүл Үрс” төвөөс 2026 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо Инчон мөрөөдлийн төгөлд мод тарих арга хэмжээг зохион байгуулав.

Тус арга хэмжээнд байгууллагын 20 албан хаагч идэвхтэй оролцож, нийт 20 ширхэг мод тарьж, усалгаа болон арчилгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн арга хэмжээний явц, үр дүнг байгууллагын дотоод болон олон нийтийн сувгаар сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа. Түүнчлэн тарьсан модыг цаашид тогтмол арчлан ургуулах, ногоон байгууламжийг хамгаалах чиглэлээр ажилтан, албан хаагчдад үүрэг чиглэл өгч ажиллав.

Энэхүү арга хэмжээ нь байгууллагын хамт олны байгаль орчноо хайрлан хамгаалах ухамсар, оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд бодит хувь нэмэр оруулсан ач холбогдолтой ажил боллоо.





Зураг 59. Мод тарих өдөр

Гамшгийн үеийн бэлэн байдал:

Эрүүл үрс төв дээр бүх нийтийн онцгой байдлын ерөнхий газрын зарлан дуудах дохиогоор 2026 оны 3-р сарын 26-ны өдрийн 16:00 цагт эрүүл үрс төвийн ажилчдад 3 алхамт бэлэн байдлын сургалт зохион байгууллаа.

- Эхний дохио дуугарахад: Газар хөдлөлтийн чичирхийлэл мэдрэгдэх үе гэж бодон барилгын даацын хана, бат бөх ширээн доогуур орж өөрийн аюулгүй байдлаа ханган түр хүлээх
- Хоёр дахь дохио дуугарахад: Газар хөдлөлтийн чичирхийлэл мэдрэгдэхээ болих үе гэж бодон баруун гарын дүрэм баримтлан, толгойгоо хамгаалж яаралтай аюулгүй талбай руу гарах
- Гурав дахь дохио дуугарахад: Барилга байгууламжид хүн үлдсэн эсэх талаар мэдэх, аюулгүй байдал хариуцсан ажилтанд бүртгүүлэх
- Гамшгийн үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлтийг нийт 5 аранз, гамшгийн үеийн иж бүрэн хувцас 5 ширхгийг бэлтгэж бэлэн болголоо.



Зураг 60. Гамшигийн сургалт

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын арга хэмжээг 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд 5 хоногийн хугацаанд зохион байгуулан ажиллалаа. Тус хугацаанд Гамшгаас хамгаалах шуурхай штабыг байгуулж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, СХД-ийн Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтнээр хянуулан батлуулж ажиллаж байна. Мөн Z-26 Цар тахлын хүрээнд 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр 3 хоногийн хугацаанд үүрэг гүйцэтгэн ажиллав.

Арга хэмжээний хүрээнд:

- Илтгэх хуудас – 4
- Судалгаа – 9
- Албан бичиг – 4-ийг тус тус боловсруулан хүргүүлсэн болно.

Дээрх ажлын хүрээнд гамшиг, халдварт өвчний үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний зохион байгуулалтыг сайжруулах, ажилтнуудын хариуцлага, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан болно.



Зураг 61. Гамшигийн сургалт

Байгууллагын засвар үйлчилгээ:

Байгууллагын дотоод орчны аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор урсгал засварыг жилд 1–2 удаа тогтмол хийж, жижүүр, слесарь, цахилгаанчин болон бусад ажилтнуудтай хамтран барилга байгууламжийн эвдрэл, элэгдлийг тухай бүрд нь сэлбэн засварлаж ажиллаж байна.

- Гал тогооны 380В-ын дөрвөн ширэмтэй цахилгаан пийшингийн ширмийг хоёр удаа сэлбэн засварласан.
- Тасаг, амбулатори, гал тогоо, коридор, эмчилгээний өрөөнүүдийн том, жижиг нүдэн гэрлүүдийг сольж шинэчилсэн.
- Тасаг нэгжүүдийн цонх болон агааржуулалтын хоолойнуудыг ялаа, шумуул нэвтрэхээс хамгаалан тороор бүрэн тоноглогсон.
- Сантехникийн урсгал засвар, үйлчилгээ
Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд дотоод хяналт болон эрсдэлийн багтай хамтран тогтмол үзлэг, шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгасан.

Сэргээн засах төвийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор Ус сувгийн удирдах газар, Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төв-16, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Хүнс хангамж, Ажин Үжин зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангаж, шаардлагатай засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэл болон бусад үйл ажиллагааг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна.



ТАЙЛАН ХЯНАСАН:

ЭЗӨД

ТАЙЛАН БИЧСЭН:

ХСХ ХАРИУЦСАН ЭМЧ

Л.Эрдэнэбулаг
А.Оюунсайхан

Л.ЭРДЭНЭБУЛАГ

А.ОЮУНСАЙХАН